**Хээрийн бүс** Монгол орны 25 хувийг эзэлж, Хангай-Хэнтийн уулархаг их нутгийг хүрээлэн, манай орны төв ялангуяа дорнод хэсэгт төвлөрнө. Дорнод Монголын тойрогт Дорнод аймгийн Хэрлэн суманд орших чулууны орд орчимд харгана бүхий жижиг дэгнүүлт үетэн-элдэвөвс-хялганат бүхий жинхэнэ хуурай хээрийн хэв шинжийг илэрхийлдэг. Энэ бүс нутаг нь ургамал-газар зүйн мужлалаар Дорнод Монголын хээрт хамаарах бөгөөд хархүрэн хөрсөнд ургах бяцхан навчит харгана, мөн үетэн-элдэв өвснөөс гялгар дэрс, байгалийн хялгана, дэрэвгэр жиргэрүү, сибирь зүрөвс, дагуур хошоон бут, юлдэн тарваган шийр, урал чихэр өвс бүхий бүлгэмдэл зонхилно.

Судалгаа явуулсан чулууны орд орчмын ашиглалтанд өртөөгүй талбай нь харгана бүхий жижиг дэгнүүлт үетэн-элдэвөвс-хялганат жинхэнэ хуурай хээрийн хэв шинжийг илэрхийлдэг. Энэ талбай нь ургамал-газар зүйн мужлалаар Дорнод Монголын хээрт хамаарах бөгөөд хүрэн хөрсөнд ургах ихэвчлэн дараах хэв шинж бүхий бүлгэмдэлтэй бэлчээр зонхилно. Үүнд:

#### **Бэсрэг толгодын хээрийн бэлчээр**

Энд ордын олборлолтонд өртөөгүй ихэнх хэсэгт харгана-үетэнт, хялгана-хазаар өвс-агьт, үетэн-агьт, үетэн-таанат бүлгэмдлүүд 50 хувьд хүрнэ. 100 м<sup>2</sup> талбайд 12-16 зүйл ургамалтай, ойролцоогоор 14-16 ц/га ургацтай болно. Алтан харгана, нарийн харгана, том хялгана, саман ерхөг, дэрвээн хазаар өвс, имт гичгэнэ, цагаан дэмэг, агь, говийн ганга, цахилдаг, ортууз, арзгар согсоот, таана, хөмөл, амманы сэдэргэнэ зэрэг ургамал голлон ургана. Ургамлын дундаж өндөр нь 20-30 см.

#### **Хуурай хээрийн бэлчээр**

Чулууны орд талбайн баруун болон хойт хэсэгт бага хэмжээгээр илрэх ба Монгол өвс-хазаар өвс-таанат бүлгэмдэл гол төлөөлөгч нь болдог. Тусгал бүрхэц нь 25 хувь, дэрсэн толботой, 100 м<sup>2</sup>-д монгол өвс, хазаар өвс, таана, хөмөл, арзгар согсоот, агь зэрэг 8-9 зүйл ургамалтай, 8-10 ц/га ургацтай. Ургамлын дундаж өндөр нь 30 см.

#### **Нам хотос, хоолой хөндийн бэлчээр**

Чулууны орд орчмын зүүн өмнөт, доод хэсгээр дэрс бүхий бударгана-таанат, дэрст, дэрс-хиагт бэлчээрийн ургамлын тусгал бүрхэц 15-20 хувь, 100 м<sup>2</sup> талбайд 10-17 зүйл ургамалтай, 10-12 ц/га ургацтай байна. Дов сондуултай, хааяа мэрэгчдэд өртсөн байх нь бий. Ургамлын дундаж өндөр нь 20 см.

#### **Ордын талбайн түүний орчмын бэлчээрийн өөрчлөлт**

Ордын эдэлбэрт өртөөгүй газар нь сум орон нутгийн газрын нэгдмэл сангийн ангиллаар ХАА-н бэлчээрийн газарт болон хамаарна. Энд антропоген болоод техноген нөлөөлөл, эх үүсвэрээс шалтгаалсан ургамлын нөмрөгийн талхагдалд орсон ч малын бэлчээр хэвийн байгаа нь энэ жил хур тунадас олон жилийн дунджаас ахиу унаж дулаарал нэмэгдэх болсонтой холбоотой болов уу. Гэвч орд олборлолт явуулсан нөхцөлд хээрийн бүсийн нам толгод тэдгээрийн хоорондох хотгор, хотос хоолой, тал

газрын сийрэг ургамалжилт бүхий элсэрхэг хүрэн хөрстэй газар нь хэрж сүлжсэн зам харгуй, хөрс хуулалтын явцад хөрсний эвдэрэлд орно. Иймд ордын хөрс хуулалт, олборолтын хэмжээ, стандартыг нарийн төлөвлөж, түүнийг мөрдөж ашиглах шаардлагатай.

Энэ хээрт бэлчээрийн ургамал нь тусгагийн бүрхэц бага ч шимт чанараар харьцангуй сайн байдаг. Бэлчээрийн ургамал нь хагдравч үндсэн дээрээ удаан хугацаагаар хадгалагдаж жилийн ихэнхи хугацаанд хагд өвстэй байдаг. Ер нь хээрийн ургамал хагдарсан үедээ бусад нутгийнхаас шим тэжээлээр илүү байдаг, иймээс энэ нутгийн бэлчээрийг хамгаалахад онцгой анхаарах шаардлагатай.

1. Хүний хүчин зүйлийн нөлөө буюу аж ахуйн үйл ажиллагаа (малталт)-ны явцад механикаар буй болсон тоос шороо ургамал болоод хөрсөн бүрхэвчид шууд нөлөөлж байдаг бөгөөд энд хөл газрын ургамал зонхилно (Зураг№4).



*Зураг №4. Ордын зүүн талд талхлагдсан ургамалжилын бүлгэмдэл.*

"ДОЦ" ХХКийн ордын үйл ажиллагаа байгаль орчинд хэрхэн нөлөөлөх вэ.

1. Юуны өмнө ойр орчмын хөрс, ургамлын бүрхэвчийг механикаар эвдэхээс гадна, тоос шороо нь орчныг салхины аясаар фотосинтезийн процесс явагдах нөхцлийг бууруулан, хөнөөх хүчин чадалтай.

2. Хөрс хуулалтыг нарийн төлөвлөгөөтэй, хянамгай хийж, хөрсний нөхөн сэргээлтийг үйлдвэрлэлийн үйл ажиллагааны салшгүй нэг хэсэг болгон явуулах шаардлагатай.

### 1.7.Тарималжуулах, ногоон байгууламж:

**Ордын олборлолтын дараах нөхөн сэргээлт.** “ДОЦ” ХХК-ийн чулууны ордын олборлолтыг явуулсаны дараах биологийн нөхөн сэргээлтийг гүйцэтгэхдээ Монгол улсад ашигт малтмалын олборлолт, нөхөн сэргээлт хийх нэгдсэн аргачлалын дагуу явуулах бөгөөд энэ ажлыг аж ахуйн нэгж болон мэрэгжлийн байгууллагын заавар зөвлөмжийн дагуу гэрээгээр гүйцэтгэнэ.

Дорнод аймгийн чулууны ордын олборлолтыг явуулахдаа хөрсний ургамал ургаж болох үржил шимтэй өнгө давхаргыг тусд нь авна. Олборлолтыг гүйцэтгээд техникийн нөхөн сэргээлт хийсний дараа үржил шимт давхаргыг буцааж хучиж, биологийн нөхөн сэргээлт хийнэ.

Биологийн нөхөн сэргээлт хийсний дараа хүн, амьтан, авто хөсөг зорчих хэсгийг тусгаарлаж, ногоон байгууламжийг хашиж хамгаалах шаардлагатай, энд ургамал тарьж нутагшуулахад байгаль цаг уурын хувьд харьцангуй тааламжтай (Номхон далайн муссон Хянганыг давж орж ирээд энд замхардаг). Иймд тухайн орон нутагт ургадаг мод, сөөг болон олон наст өвслөг ургамал сонгож авах нь зүйтэй бөгөөд өөр орон нутгаас гоёл чимэглэлийн хийгээд жимс, жимсгэнэт сөөг, сөөгөнцөр, олон наст өвслөг ургамлыг ч тарьж нутагшуулах боломжтой юм. Үүний тулд услалтын асуудлыг ч мөн бүрэн шийдэх (худаг ухах) хэрэгтэй (Хүснэгт №2).

#### *Хүснэгт №2. Лицензийн талбайд нөхөн сэргээхэд ашиглах зүйл ургамал*

Дээж авсан цэг	Ургамалжилтын хэв шинж	Нөхөн сэргээхэд ашиглах	
		Мод, сөөг ургамал	Олон наст өвслөг ургамал
1	Үетэн - алаг өвст хээр (128/Х-II-2-7)	Одой хайлас, лаврнавчит улиас, хус зэрэг мод, бариулт бүйлэс, удвалнавчит тавилгана, дагуур сарнай /нохойнхушуу/, сибирь гүйлс, харганын төрлийн сөөг ургамал тарих нь зүйтэй.	Саман ерхөг, хялгана, цагаалин цахилдаг болон гадаад, дотоодын олон наст ургамал
2-3	Ботууль-жижиг дэгнүүлт үетэн-алаг өвст хээр (102/Х-I-2-1)		
4-5	Алаг өвс - агь - үетэнт хээр (56/У-V-2-1)		
6-7	Жижиг дэгнүүлт үетэн - алаг өвст (42/ У-IV-2-11)		
8	Хялганат, хялгана-алаг өвст(110/Х-I-2-9)		

**Ордын ажилчдын хотхоны хамгаалалтын зурвас**-ыг байгуулахдаа олборлолтын талбайн байгуулалтын зургийг үндэслэн мод, сөөг, сөөгөнцөр ургамлыг 2-3 эгнээ тарина. Зурвасын гадна талаас:

1-р эгнээнд. Улиас, хайлаас, хус, шинэс зэрэг модыг 2-3 метрийн зайтай сөөлжүүлэн тарина.

2-р эгнээнд. Сөөг, сөөгөнцөр ургамлын үрслэг, суулгацыг 40-50 см өргөнтэй, 20 см-ийн гүн шуудуунд 20-30 см-ийн зайтай тарина.

**Олон наст өвслөг ургамал:** Олборлолтын дараа нөхөн сэргээлтийн хэсэгт нэг болон олон настын үрийг 1x1 м<sup>2</sup> талбайд 10-20 гр-аар тооцож тарина. Үрийг 1-2 см-ийн гүнд суулгаж элсээр хучиж шүршүүрээр услана. Эхний 1 сард өдөр алгасч услах ба тарьснаас хойш 2-3 сарын дараа 3-4 хоног өнжөөд услана.

**1.8.Бичиглэл хийсэн талбай, цэг**

**Бичиглэл №1**

**Газрын нэр:** Дорнод аймгийн Хэрлэн сумын 3-р багийн нутаг дэвсгэрт орших Чулууны “ДОЦ” ХХК-ийн орд ДО-002А тоот тусгай зөвшөөрөлтэй талбайн зүүн урд хэсэгт.

**Солбилцол:** 48°03'14.7"N 114°25'12.4"E h = 762 м

**Бүлгэмдлийн нэр:** Хялгана – хазаар үетэн – алаг өвст бүлгэмдэл

**Ургамлын бүрхэц:** 25-30%



Зонхилох ургамал	Арви	Бүрхэц	Дагалдах ургамал
<i>Stipa baicalensis</i>	Сор <sub>1</sub>	10	<i>Artemisia frigida</i>
<i>Cleistogenes squarrosa</i>	Sp	5	<i>Orostachys fimbriata</i>
<i>Caragana stenophylla</i>	Sol	2	<i>Allium polyrrhizum</i>
			<i>Haplophyllum dauricum</i>
			<i>Artemisia scoparia</i>
			<i>Caragana microphylla</i>
			<i>Achnatherum splendens</i>
			<i>Saussurea amara</i>

**Тэмдэглэл:** Энд одоогоор үйл аижллагааны талхагдалд өртсөн, хялганат хуурай хээрийг төлөөлнө.

### Бичиглэл №2

**Газрын нэр:** Дорнод аймгийн Хэрлэн сумын 3-р багийн нутаг дэвсгэрт орших Чулууны “ДОЦ” ХХК-ийн орд ДО-002А тоот тусгай зөвшөөрөлтэй талбайн зүүн урд хэсэгт.

**Солбилцол:** 48° 08' 00.9", 114° 32' 18.8"      h = 768 м

**Бүлгэмдлийн нэр:** Жижиг дэгнүүлт үетэн – алаг өвст хээр

**Ургамлын бүрхэц:** 30-40%



Зонхилох ургамал	Арви	Бүрхэц	Дагалдах ургамал
<i>Stipa baicalensis</i>	Cop <sub>1</sub>	10	<i>Artemisia scoparia</i>
<i>Cleistogenes squarrosa</i>	Cop <sub>1</sub>	10	<i>Orostachys fimbriata</i>
<i>Achnatherum splendens</i>	Cop <sub>1</sub>	10	<i>Leymus chinensis</i>
<i>Artemisia frigida</i>	Sp	5	<i>Caragana microphylla</i>
			<i>C. stenophylla</i>
			<i>Saussurea amara</i>
			<i>Salsola collina</i>
			<i>Allium polyrrhizum</i>

**Тэмдэглэл:** Алаг өвс – үетэн зонхилсон (хүрэн хөрстэй) бага зэргийн гүдгэрдүү гадарга нь хуурай хээрийг төлөөлнө.

**Бичиглэл №3**

**Газрын нэр:** Дорнод аймгийн Хэрлэн сумын 3-р багийн нутаг дэвсгэрт орших Чулууны “ДОЦ” ХХК-ийн орд ДО-002А тоот тусгай зөвшөөрөлтэй талбайн урд хэсэгт.

**Солбилцол:** 48°03'11.6"N 114°25'10.0"E h = 762 м

**Бүлгэмдлийн нэр:** Хялгана – хазаар үетэн – алаг өвст бүлгэмдэл

**Ургамлын бүрхэц:** 25-30%



Зонхилох ургамал	Арви	Бүрхэц	Дагалдах ургамал
<i>Stipa baicalensis</i>	Сор <sub>1</sub>	5	<i>Artemisia frigida</i>
<i>Cleistogenes squarrosa</i>	Sp	10	<i>Orostachys fimbriata</i>
<i>Caragana stenophylla</i>	Sol	2	<i>Allium polyrrhizum</i>
			<i>Haplophyllum dauricum</i>
			<i>Artemisia scoparia</i>
			<i>Caragana microphylla</i>
			<i>Achnatherum splendens</i>
			<i>Saussurea amara</i>

**Тэмдэглэл:** Энд одоогоор үйл аижлагааны талхагдалд өртсөн, хялганат хуурай хээрийг төлөөлнө.

### 1.9. Ургамлан бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зөвлөмж

Ордын үйл ажиллагаа болон овоолго шорооноос ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллөөс зайлс хийх боломжгүй ч доорх арга зөвлөмжүүдийг авч хэрэгжүүлснээр сөрөг нөлөөллийг бууруулах, хянах, сайжруулах бүрэн боломжтой.

- I. Ордын дотоод төлөвлөлт, газар ашиглалтыг зөв хийж ургамлан нөмрөгт сөрөг нөлөөлөл үзүүлэх талбайг хамгийн бага хэмжээнд төлөвлөх, ордын дотоод овоолгыг аль болох их хийж хаягдал чулуулгийн овоолгын талбайг багасгах арга хэмжээг авч ажиллах хэрэгтэй.
- II. Авто замаас ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахын тулд төслийн хэмжээнд авто замын маршрут төлөвлөлтийг маш сайн хийх, нэг замын бодлого боловсруулж түүнийг чанд мөрдөж ажиллах, ордын бүсэд хурдны дээд хязгаарын тогтоож ажиллах, байнга ашиглагдах зам талбайг хатуу хучилттай болгох, замаас үүсэх тоосжилтыг бууруулах үүднээс усалгаа арчилгаа тордолтын арга хэмжээг байнга гүйцэтгэж байх хэрэгтэй. Авто замын 2 талаар мод бут сөөг тариалах хамгаалалтын ногоон зурвас байгуулах гэх мэт арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх.
- III. Ургамал сийрэгших, төрөл зүйлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт ороход гол нөлөөлж буй хүчин зүйлийн нэг яах аргагүй тоосжилт болох юм. Иймээс тоосжилтыг бууруулахын тулд төслийн талбайд хурдны хязгаарлалтыг тогтоож маш сайн хэрэгжүүлж ажиллах хэрэгтэй, өндөр ачаалалтай шороон замуудын усалгаа чийгшүүлэлтийг нэмэгдүүлэх, авто зогсоолуудыг хатуу хучилттай болгох шаардлагатай.
- IV. Шимт хөрсний овоолгыг тусгай талбайд хуримтлуулж стандартын дагуу хадгалж хамгаалах арга хэмжээ авч хэрэгжүүлэх, хадгалах хугацаанд гадаргууг ургамалжуулж хөрс бүтэц шинж чанараа алдах, салхиар хийсэх, үерийн усаар угаагдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх. Мөн хашаажуулах шаардлагатай.
- V. Хаягдал чулуулгийн овоолгыг стандартын дагуу өндөр, налуу үүсгэж хэлбэржүүлэх, гадаад овоолгыг аль болох хамгийн бага хэмжээнд үүсгэх, түлхүү дотоод овоолго үүсгэж нөхөн дүүргэлтэд ашиглахад хялбар байх нөхцөл бололцоогоор хангах, үйл ажиллагааны явцад хаягдал чулуулгийн овоолгыг нөхөн сэргээх ургамалжуулах туршилт судалгааны ажлыг хийж үр дүнг харгалзан ордын хаалтын нөхөн сэргээлтийн төлөвлөгөөг боловсруулах нь зүйтэй.
- VI. Төслийн талбайн нөлөөлөлд өртсөн зам талбайг ургамалжуулах, мод бут тариалах нь тухайн орчинд агаарын бохирдлыг бууруулах, тухайн орчны иргэд болон хотхоны ажилчдын эрүүл таатай орчинд амьдрах нөхцөл бололцоог бий болгох, сөрөг нөлөөллийг бууруулах олон талын эерэг ач тустай юм.
- VII. ШУА Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнгээс 21 аймгийн 330 суманд тарих боломжтой сөөг болон модлог ургамлын жагсаалтыг гаргасан бөгөөд Дорнод аймгийн Хэрлэн суманд Яшилдуу Чацаргана - *Hippophae rhamnoides* L., Азийн Монос (Мойл) - *Padus asiatica* Kom., Үслиг Улиас - *Populus pilosa* Rehd., Анхилуун Улиас - *Populus suaveolens* Fisch., Том үрт Хайлас - *Ulmus macrocarpa* Hance., Одой Хайлас - *Ulmus pumila* L., Бариулт Бүйлэс - *Amygdalus pedunculata* Pall., Сибирь Гүйлс - *Armeniaca sibirica* (L.) Lam., Ледебурын Бургас - *Salix ledebouriana* Trautv., Бяцхан молцогт

- Бургас - *Salix microstachya Turcz.*, Миабейн Бургас - *Salix miyabeana Seemen.*, Хуурамч таван дохиурт Бургас - *Salix pseudopentandra Flod.*, гэх мэт мод болон сөөг ургамлыг ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд сум орон нутагтай хамтран тохиромжтой газруудад хэрэгжүүлэх нь зүйтэй.
- VIII. Нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгэхдээ овоолгын налуу, шимт хөрсний зузаан, тариалах үрийн хэмжээ, суулгах гүн зэрэг агротехнологийн нөхцөл болон тариалалт хийх хугацааг тогтоохдоо Монгол Улсын MNS5914:2008, MNS 5915:2008, MNS5916:2008, MNS5917:2008, MNS5918:2008 зэрэг стандартууд болон олон улсын шилдэг туршлагыг хослуулан хэрэгжүүлэх. Нөхөн сэргээлтэд тухайн бүс нутгийн онцлогт тохирсон үет ургамлын төрөл зүйлийг түлхүү ашиглах шаардлагатай. Байгалийн болон нутгийн ургамлын үрийг цуглуулан нөөц санг бий болгох нөхөн сэргээлтэд хэрэглэх. Нөхөн сэргээлтийн туршилт судалгааны талбай бий болгож түүнд нутгийн ургамлын үрийг тарьж турших арга хэмжээг авч хэрэгжүүлэх, Нөхөн сэргээлтэд мэргэжлийн байгууллага орон нутгийн иргэн, аж ахуй нэгж байгууллагуудыг татан оролцуулах зайлшгүй шаардлагатай.
- IX. Тухайн төслийн үйл ажиллагааны явцад нөлөөлөлд өртсөн талбайг биологийн аргаар нөхөн сэргээхдээ “Эвдэрсэн газрыг ургамалжуулах, техникийн ерөнхий шаардлага MNS 5918:2023 стандартын дагуу хийж гүйцэтгэх бөгөөд тухайн стандартад тусгагдсан хээрийн бүсэд зонхилон ургадаг үет ургамлууд мөн Монгол улсад үрийн олдоц сайтай ургамлууд болох Саман ерхөг (*Agropyron cristatum*), Цагаан суль буюу хиаг (*Elymus chinensis*), Соргүй согоовор (*Bromus inermis*), Ботууль (*Festuca sp*) гэх мэт төрөл зүйлийг түлхүү ашиглах бол сөөг ургамлаас тухайн бүс нутагт ургадаг 2 зүйл харгана болох Жижиг навчит Харгана (*Caragana microphylla*), Нарийн навчит Харгана (*Caragana stenophylla*) 2 зүйл харганы үрийг байгаль дээрээс түүж нөхөн сэргээлтэнд ашиглах. Мөн зарим үет ургамлын үрийг байгаль дээрээс түүж үрийн сан бий болгож нөхөн сэргээлтэнд ашиглах нь зүйтэй: Нөхөн сэргээлтийг хийхдээ үрийн нормыг MNS:5918:2023 стандартад тусгагдсаны дагуу 1 га талбайд 60 – 80 кг холимог үр байх бөгөөд уг үрийн хольцод үетэн 50 – 60%, буурцагтан 20%, бусад ургамал 20% байхаар тооцоолох нь зүйтэй.
- X. Уг төсөл хэрэгжсэнээр тухайн орчны мэлчээрт ямар нэгэн хэмжээнд сөргөөр нөлөөлж буй учир ордын ойр орчмын айлуудад өвөл хавартаа бэлчээрийн дэмжлэг үзүүлж өвс нэмэлт тэжээлийг цаг хүндэрсэн жилүүдэд авч өгч байх.
- XI. “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө” ний хүрээнд байгаль орчны хяналт шинжилгээний ажлыг мэргэжлийн судлаач, эрх бүхий байгууллагаар хийлгүүлж ургамлын хяналт мониторингийг жил бүр хэрэгжүүлж ажиллах хэрэгтэй.
- XII. Хээрийн түймрээс болгоомжлох, гал түймрийн аюулгүй байдлыг маш сайн хангаж, ажилчдад заавар зөвлөмж байнга өгч байх. Мөн ордын хэмжээнд хээрийн түймрийн эрсдэлээс сэргийлэх төлөвлөгөө боловсруулан ажиллах зайлшгүй шаардлагатай. Мөн төслийн талбайн гадна хэсгээр түймрээс хамгаалах зурвас шуудуу татаж жил бүр сэргээн ажиллах шаардлагатай.

### ДҮГНЭЛТ

1. “Овоот” нэртэй талбай нь Улаанбаатар хотоос зүүн тийш 650 км-т Дорнод аймгийн Хэрлэн сумын нутагт Чойбалсан хотоос баруун тийш 7.5 км-т Хэрлэн голын хойд талд 803.0 тоот өндөрлөгтэй Овоот уулаас 3Х 70 хэмээр 500 метр зайд М-50-133 хавтгайд байрлана.
2. Хээрийн судалгааны үед 1м<sup>2</sup> талбайд 9-13 зүйл ургамал тэмдэглэгдэж байв. Хялгана, Саман ерхөг, Дааган сүүл, Дэрвээн хазаар өвс зэрэг үетэн ургамал бас Дэрвээн буржгар, дагуур хатны цэцэг, Дагуур хүж өвс, дэлхээ тогторгоно, анхил сонгино зэрэг ургамлууд их бага хэмжээтэй бүлгэмдэлд байнга тохиолдож байна. Төслийн талбайн ургамлын тусгаг бүрхэц их газраа 85-90%, дундаж газраа 50-60% бага газраа 30-45% -ийн бүрхэцтэй байв. Төслийн талбайд 6 төрлийн ургамлан бүлгэмдлийг дагаж 22 овогт хамаарах 60 орчим төрлийн 67 зүйл ургамлыг бүртгэсэн.
3. “ДОЦ” ХХК-ийн чулууны орд нь баруун хойноос зүүн хойт (ерөнхийдөө хойт хэсэг) хэсгийг дагаж хуурай хээрийн дэгнүүлт үетэнт, хялгана-жижиг дэгнүүлт үетэнт, хялгана-агьт хээр тааралдаж байхад, зүүн хэсэг, өмнөд биеэр хялгана-хазаар өвс- алагөвст, үетэн- шарилж- алагөвст хээрийн бүлгэмдэл байдаг.
4. Судалгаа явуулсан орд орчмын ашиглалтанд өртөөгүй талбай нь харгана бүхий жижиг дэгнүүлт үетэн-элдэвөвс-хялганат жинхэнэ хуурай хээрийн хэв шинжийг илэрхийлдэг. Энэ талбай нь ургамал-газар зүйн мужлалаар Дорнод Монголын хээрт хамаарах бөгөөд хүрэн хөрсөнд ургах ихэвчлэн дараах хэв шинж бүхий бүлгэмдэлтэй бэлчээр зонхилно.
5. Дорнод аймгийн Хэрлэн сумын нутагт байрлах “ДОЦ” ХХК-ийн чулууны орд 26.67 га талбайд талын элсэрхэг хүрэн хөрс тархсан байна. Эл хөрсний 0-24 см-ын гүнд ялзмагийн агууламж 1,6-1,7% буюу дунджаар 1,65% байна. Хөрс нь уусмлын орчин (рН 7.6-8,9) дунд шүлтлэг, давсгүй гэх мэт агрохимийн “сайн” үзүүлэлтүүдийг хадгалж байна.
6. Элсэнхэг хүрэн хөрсний хувьд хүнд металлуудын агууламж зөвшөөрөгдөх хэмжээнээс 1-12 дахин бага байна.
7. Төслийн талбайд нийт 3 цэгт ургамлын бүрэн бичиглэл хийхэд тус цэгүүдийн орчимд ургамлын тусгагийн бүрхцийг бүс нутгийн дундаж бүрхэцтэй харьцуулан үзэхэд 3 цэгт бүс нутгийн дунджийн хэмжээнд буюу 30-40% харин 1 цэгийн ургамлын бүрхэц бүс нутгийн дунджаас бага зэрэг бага байна.



# “НАРТ ШУҮН КОНСАЛТИНГ” ХХК ХӨРСНИЙ ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ



Монгол улс, Улаанбаатар хот, Сонгино Хайрхан  
дүүрэг, 19-р хороо, ҮЭГ, ЗК 17024 Ш/х 10  
Утас: (976)-99176123, 99231836

E-mail: nartconsulting@gmail.com

№ 25/05-20/2

Захиалагч: “Доц” ХХК

Дээж авсан цэг: Дорнод аймаг, Хэрлэн сум, 3-р баг, чулууны орд

Сорьц авсан огноо: 2025 оны 05 сар 07 өдөр

Шинжилгээ хийсэн огноо: 05 сарын 20

## 1. ХӨРСНИЙ ХИМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

№	Дээж авсан гүн, см	pH	Давс, %	ЦДЧ, ds/m	Ялзмаг, %	CaCO <sub>3</sub> , %	NO <sub>3</sub> , мг/100г	Солилцох сууриуд, мг-экв/100 г		Шим тэжээлийн элементүүд, мг/100г	
								Ca <sup>+2</sup>	Mg <sup>+2</sup>	P <sub>2</sub> O <sub>5</sub>	K <sub>2</sub> O
Зүс 1											
1	0-49	8.60	0.016	0.039	1.76	0.00	0.09	12	9	1.8	5
Зүс 3											
3	63-78	9.33	0.024	0.059	0.51	2.08	0.17	6	11	0.6	4
Зүс 4											
4	0-35	8.92	0.012	0.028	2.13	0.00	0.05	13	10	1.7	5
Зүс 6											
6	50-68	8.70	0.135	0.328	1.03	1.92	1.28	8	12	0.4	5

## 2. ХӨРСНИЙ МЕХАНИК БҮРЭЛДЭХҮҮН

№	Дээж авсан гүн, см	Механик ширхэгүүд, % ширхэгийн хэмжээ, мм						
		1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01
Зүс 1								
1	0-49	15.3	60.6	10.5	7.3	2.1	4.2	13.6
Зүс 3								
3	63-78	16.9	64.5	7.3	5.4	1.2	4.7	11.3
Зүс 4								
4	0-35	4.9	66.6	11.6	7.9	3.7	5.3	16.9
Зүс 6								
6	50-68	10.9	63.9	8.5	6.7	3.8	6.2	16.7

## 3. ХӨРСНИЙ ХҮНД МЕТАЛЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Дээж авсан газар, Газар зүйн байршил	Дээж авсан гүн, см	Cr	Pb	Cd	Zn	Cu	Ni
		мг/кг	мг/кг	мг/кг	мг/кг	мг/кг	мг/кг
Зүс 2	49-63	23.2	40.0	0.0	59.4	14.7	1.0
Зүс 5	35-50	24.2	36.5	0.0	65.8	18.5	7.2
Зөвшөөрөгдөх дээд хэмжээ, MNS 5850:2019							
Элсэрхэг хөрс		60	50	1	100	60	60
Шавранцар хөрс		100	70	1.5	150	80	100
Шаварлаг хөрс		150	100	3	300	100	150

\*Харгалзах түвшин \* Жич: Энэхүү шинжилгээний хариу нь тухайн цэгийн дээжэнд хамаарна

ЗАДЛАН ШИНЖИЛГЭЭНИЙ АРГЫН СТАНДАРТУУД : (Хөрсний агрохимийн үзүүлэлтүүд  
MNS3310:1991, MNS ISO10390, хөрсний механик бүрэлдэхүүн MNS6824:2020, Хүнд металлуудыг -  
хаан дарсанд атом шингээлтийн спектрометрээр MNS ISO 11466:2007)

ЗАДЛАН ШИНЖИЛГЭЭГ ГҮЙЦЭТГЭСЭН: *Овоодорж* Х.УУГАНЦЭЦЭГ, С.НЯМДАШ  
ХЯНАСАН ЛАБОРАТОРИЙН ЭРХЛЭГЧ : *Овоодорж* Г.СОЛОНГО Ph.D, Дэд профессор



Нарт ШУҮН Консалтинг ХХК

БАТЛАВ.  
"ХЭРЛЭН ТОХИЖИЛТ  
ҮЙЛЧИЛГЭЭ" ОНӨААТҮГ-ИЙН  
ЗАХИРАЛ *М.АЛТАНХУЯГ*

БАТЛАВ.  
"ДОЦ" ХХК  
ЗАХИРАЛ *Б.БАЗАРГҮР*

### ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

2025 оны 01 сарын 31 өдөр

Чойбалсан хот

Нэг талаас "Хэрлэн тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ (цаашид "А" тал гэнэ), түүнийг төлөөлөн Ерөнхий нягтлан бодогч ажилтай Өлзийхутаг овогтой Пүрэвсүрэн

Нөгөө талаас түүнийг төлөөлж захирал албан тушаалтай Б.Базаргүр (цаашид "Б" тал гэнэ), /РД:2011506/ бид дараах нөхцөлөөр энэхүү гэрээг байгуулав.

#### 1. "А", "Б" талын нийтлэг үндэслэл

1.1. "А", "Б" талууд нь хүний эрүүл мэнд хүрээлэн байгаа орчинд үзүүлэх хортой нөлөөллийг арилгах түүнээс урьдчилан сэргийлэх хоггүй цэвэр орчинд ажиллаж, амьдрах зорилгоор тогтоосон хуваарийн дагуу хаягдал хогийг цуглуулан тээвэрлэж хамтран ажиллана.

1.2. Гэрээний хугацааг "А", "Б" талууд 2025 оны 01 дугаар сарын 31-ны өдрөөс 2026 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл хугацаатай байгуулав. /Гэрээний хугацааг талууд тохиролцон сунгаж болно./

#### 2. "А", "Б" талын хамтын ажиллагааны удирдлага, хяналт

2.1. "А", "Б" тал нь гэрээний хэрэгжилт болон талуудын гэрээний талаарх үйл ажиллагаанд хяналт тавих эрхтэй.

2.2. Талууд аль нэг талынхаа шаардсан үед хамтын ажиллагаатай холбоотой өөрийн хийсэн ажлын талаар тайлагнаж болно.

#### 3. Нэг. "А", "Б" талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг

3.1. "Б" тал нь гэрээнд заагдсан хэмжээ, хугацаанд хог хаягдлыг тээвэрлүүлнэ.

3.2. "Б" тал нь хог хаягдлын хураамж **100,000 /Нэг зуун мянган/** төгрөгийг Захиргааны хэм хэмжээний актын 2023 оны 07.28-ны өдрийн 6325 дугаарт бүртгэлтэй Дорнод аймаг Хэрлэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023.06.30-ны өдрийн 14/01 тоот тогтоолоор батлагдсан хураамжийн дагуу тооцон "А" талын Хаан банкны **5423157489** тоот дансанд сар бүрийн 25-ны дотор шилжүүлэх

3.3. "А", "Б" тал нь "Хог хаягдлын тухай" хуулийн 10 дугаар зүйлийг мөрдлөг болгон ажиллана.

3.4. "Б" тал нь "А" талд хог хаягдлын хураамжийг төлөөгүй тохиолдолд хог хаягдлыг тээвэрлэхгүй.

3.5. "А" тал хог хаягдлыг гэрээнд заагдсан хугацаанд аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан тусгай тоногдсон автомашинаар тээвэрлэнэ.

3.6. "А" тал нь "Б" талын хог хаягдлыг **сард 1 удаа** ачиж тээвэрлэнэ.

3.7. Тус гэрээний нэмэлт заалтад дурдсан эрх үүрэг, хориглох заалтыг иргэн, аж ахуйн нэгж байгууллагууд тус тусын мөрдөх хэсгийг мөрдлөг болгон ажиллана.

3.8. "А" тал нь "Б" талын хог хаягдлыг сард дуудлагаар болон төлөвлөсөн хуваарийн дагуу ачиж тээвэрлэх явцад "Б" тал нь "А" талд хогийг цогтой үнс нурмын хамт ачуулахыг хориглоно.

3.9. "Б" тал хогийг цогтой үнс нурмын хамт ачуулсан нь тогтоогдож, "А" талд эрсдэл учруулбал учирсан хохирлыг буруутай байгууллага, аж ахуйн нэгж хариуцан төлнө.

3.10. Хог хаягдлын тухай хуулийн 41.3-т заасан овор хэмжээ ихтэй болон барилгын хог хаягдлыг тээвэрлэх, устгах үйлчилгээний хөлс нь энэ хуулийн 41.1-д заасан хураамжид хамаарахгүй, 41.4. энэ хуулийн 41.2, 41.3-т заасан үйлчилгээний хөлсийг хог хаягдлыг хүлээн авах иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай байгуулах гэрээний үндсэн дээр тохиролцон тогтооно гэж заасны дагуу дараах заалтын дагуу үнэ тарифыг баримтлан "Б" тал нь "А" талын дансанд төлбөрийг шилжүүлнэ.

3.11. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийг үүсгэж байгаа хог хаягдлын хэмжээнээс хамааруулан тооцно.

3.12. Дорнод Аймаг Хэрлэн сумын Засаг даргын 2022 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн А/199 Шинээр байгуулсан хогийн цэгт хог хаягдлыг тээвэрлэх тухай захирамжийн дагуу Хэрлэн сум, Чойбалсан хотод үйл ажиллагаа явуулж буй Хоол үйлдвэрлэл болон мах, махан бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, зам, барилгын компанийн хог хаягдлыг 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн Баянтүмэн сумын нутаг дэвсгэр дэх шинэ хогийн төвлөрсөн цэгт татан зайлуулна.

3.13. Баян түмэн сумын шинэ хогийн цэгт хоол үйлдвэрлэл, малын гаралтай бүтээгдэхүүн, сэг зэм, яс, зам болон барилгын хаягдал хогийг татан зайлуулах өртөг нь байршлаас шалтгаалан бусад энгийн хог хаягдлаас илүү төлбөртэй байна.

3.14. Баян түмэн сумын шинэ хогийн цэгт хог тээвэрлэх хуваарийн /хавсралт-1/-ийн дагуу хийж гүйцэтгэж болно.

#### **4. Маргааныг шийдвэрлэх**

4.1. Гэрээгээр хүлээсэн үүрэгтэй холбоотой асуудлаар 2 тал харилцан зөвшилцөн, тохиролцоонд хүрээгүй тохиолдолд холбогдох хуулийн байгууллагаар шийдвэрлүүлнэ.

#### **5. Бусад нэмэлт заалт**

5.1. "А" "Б" талууд үйл ажиллагаандаа Монгол Улсын Иргэний тухай хууль, Хог хаягдлын тухай хууль тогтоомж, бусад хууль тогтоомжийг удирдлага болгоно.

5.2. Хог хаягдлын талаар иргэн, аж ахуйн нэгж байгууллагын эрх, үүрэг

5.2.1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага дараах эрх эдэлнэ:

5.2.2. Хог хаягдлын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдийн талаар төрийн болон нутгийн захиргааны байгууллагад мэдээлэх, хариуцлага хүлээлгэхийг эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас шаардах;

5.2.3. Хог хаягдлын талаар мэргэжлийн байгууллагаас арга зүйн туслалцаа, зөвлөгөө авах

**5.3. Хог хаягдлын талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллага дараах үүрэг хүлээнэ:**

5.3.1. Хог хаягдлын тухай хуулийн 9.1.3-т заасан журмын дагуу энгийн хог хаягдлаа ангилан ялгах.

5.3.2. Хог хаягдлын тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан хогийн савтай байх.

5.3.3. Аж ахуйн нэгж, байгууллага нь хог хаягдал цуглуулах, тээвэрлэх эрх бүхий аж ахуйн нэгж, байгууллагатай буюу /"Хэрлэн тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ-тай/ хог тээврийн үйлчилгээний гэрээ байгуулах,

5.3.4. Хог хаягдлаа зориулалтын хогийн сав болон цэгт хаях эсхүл хог хаягдал цуглуулж тээвэрлэх эрх бүхий байгууллага буюу /"Хэрлэн тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ-т/ шилжүүлэх;

5.3.5. Нийтийг хамарсан цэвэрлэгээ, иргэдийн бүлгээс зохион байгуулсан үйл ажиллагаанд идэвхитэй оролцох;

5.3.6. Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг тогтоосон хугацаанд төлөх

5.3.7 Хог хаягдлыг бууруулах, ангилах, дахин ашиглах, зүй зохистой хаях дадал зуршлыг хэвшүүлэх;

5.3.8. Эзэмшлийн барилга, байгууламжийн гадна хана, хашаа, хайсан дээр хог хаягдал болохоор зар сурталчилгаа байршуулахгүй байх;

5.3.9. Хог хаягдлын тухай хуулийн 9.4.12-т заасан нийтийн эдэлбэр газрын 50 метр хүртэлх хог хаягдал, цас, мөсийг цэвэрлэх;

5.3.10. Барилга барих, буулгах, засварлах үйл ажиллагаанаас гарах хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах, булшлах эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад шилжүүлж, үйлчилгээний хөлсийг хариуцах;

5.3.11. Хог хаягдлын талаарх сургалтад хамрагдаж, мэдлэгээ дээшлүүлэх;

5.3.12. Хамгийн боломжит арга технологи, байгаль орчинд ээлтэй арга ажиллагааг нэвтрүүлэх замаар хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах,

5.3.13. Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага хог хаягдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавина.

**5.4. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хог хаягдалтай холбоотой дараах үйл ажиллагааг хориглоно.**

5.4.1. Хог хаягдлыг дэд бүтцийн шугам хоолойд хаях;

- 5.4.2. Нийтийн эдэлбэр газар, ногоон бүс, үерийн далан сувагт хог хаягдал хаях;
- 5.4.3. Хог хаягдлыг ил задгай шатаах;
- 5.4.4. Гэрийн болон нам даралтын зууханд нийлэг материалтай хог хаягдлыг шатаах;
- 5.4.5. Хог хаягдлыг хогийн сав болон тогтоосон цэгээс бусад газарт хаях;
- 5.4.6. Аж ахуйн нэгж, байгууллага нь хөрс бохирдуулагч жорлон байгуулах;
- 5.4.7. Нийтийн эзэмшлийн эд хөрөнгө дээр зар сурталчилгаа байршуулах, шашны болон зан үйлийн эд зүйлс тавьж хог хаягдал үүсгэх.

## 6. Гэрээ хүчин төгөлдөр байх

- 6.1. "А", "Б" талууд нь гэрээнд гарын үсэг зурсан үеэс гэрээ хүчин төгөлдөр болж мөрдөгдөнө.
- 6.2. Гэрээг хуульд зааснаас бусад тохиолдолд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр хугацаанаас өмнө ажлын 10 хоногийн дотор урьдчилан мэдэгдэх замаар гэрээг цуцалж болно. Энэ тохиолдолд шалтгааныг тодорхой бичин албан тоотоор хандана.
- 6.3. Талууд харилцан тохиролцож гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

## 7. ГЭРЭЭ БАЙГУУЛАГЧ ТАЛУУД:

А" тал:

Хаяг:  
Хэрлэн сум 2-р баг  
"ХЭРЛЭН ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭ"  
ОНӨААТҮГазрын Ерөнхий нягтлан  
Бодогч /Ө.Пүрэвсүрэн/



/Гарын үсэг/

Тамга, тэмдэг

Утас: 80822832

Б" тал:

Хаяг:  
Хэрлэн сум 3-р баг  
"Доц"ХХК  
Нягтлан бодогч



/Гарын үсэг/

Тамга, тэмдэг

Утас:99573030

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын  
2019 оны А/618 дугаар журмын 4 дүгээр  
хавсралт

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
БИЕЛЭЛТИЙГ ДҮГНЭСЭН АЖЛЫН ХЭСГИЙН ДҮГНЭХ ХУУДАС.

Дугаар: 09

Огноо: 2025-11-11

Дорнод аймгийн Хэрлэн сумын нутагт "Овоот" нэртэй барилгын чулууны ордод ашиглалтын үйл ажиллагаа явуулж байгаа "ДОЦ" ХХК-ийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт / ... 92.6 / хувьтайгаар дүгнэгдлээ.

Дорнод аймгийн Засаг даргын 2020 оны А/500 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг

Дарга:  
А.Гантулга



-Байгаль орчны газрын дарга

Нарийн бичгийн дарга:  
Н.Сүх-Ялалт

-Байгаль орчны газрын газрын хэвлий, түүний баялагийн ашиглалт, нөхөн сэргээлт, Газарзүйн мэдээллийн систем хариуцсан мэргэжилтэн

Гишүүн:

Н.Билгүүнзаяа

- Байгаль орчны газрын байгаль орчны хяналтын улсын байцаагч

С.Урантогос

-Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Орчны бохирдол, химийн бодис хариуцсан мэргэжилтэн

Б.Батдорж

-Хэрлэн голын сав газрын захиргааны мэргэжилтэн

Ж.Саран

-Хэрлэн сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч


Т.Болдбаатар

-Хэрлэн сумын байгаль хамгаалагч

Б.Бат-оргил

-Хэрлэн сумын 3 дугаар багийн Засаг дарга

Хүлээн зөвшөөрсөн: "ДОЦ" ХХК –ийг төлөөлж

..... 

“ЭВДЭРСЭН ГАЗАРТ НӨХӨН СЭРГЭЭЛТ ХИЙСЭН  
ГАЗРЫГ ХҮЛЭЭЖ АВАХ АКТ”

№

2025 оны 11 дугаар сарын 11-ний өдөр

1. Байршлын мэдээлэл		
1.1.	Аймаг, нийслэлийн нэр	Дорнод
1.2.	Сум, дүүргийн нэр	Хэрлэн
1.3.	Газрын нэр	Хэрлэн сумын 3 дугаар багийн Овоотын зүүн талд
2. Нөхөн сэргээлт хийсэн байгууллагын мэдээлэл		
2.1	Нөхөн сэргээлт хийсэн аж ахуй нэгжийн нэр, регистр	“ДОЦ” ХХК РД: 2011506
2.2	Хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр	/компани хөрөнгө/
2.3	Тус газрын эвдрэлд өртсөн шалтгаан	Хэрлэн сумын 3 дугаар багийн нутаг Оросуудын зам тавих ажилд ашиглагдаж байсан орхигдсон карьер
2.4	Тус талбайд нийт эвдрэлд өртсөн талбайн хэмжээ (га)	...
2.5	Газрын хэвлийн нөхөн сэргээлт хийх мэргэжлийн байгууллагын эрхтэй эсэх, зөвшөөрлийн дугаар	ДО-002А тоот тусгай зөвшөөрөл эзэмшигч уул уурхайн “ДОЦ” ХХК 2025 оны дүйцүүлэн хамгааллын арга хэмжээний хүрээнд техникийн нөхөн сэргээлтийн ажлыг өөрийн техник, хүн хүч, хөрөнгөөр хийсэн.
3. 2025 онд хүлээлгэн өгч буй нөхөн сэргээлтийн мэдээлэл		
Техникийн нөхөн сэргээлт		Биологийн нөхөн сэргээлт Байхгүй
- Талбайн хэмжээ: 0,46 га		
- Зардлын хэмжээ: 7500 мян.төг		
4. Орон зайн мэдээлэл		
4.1 Нөхөн сэргээлт хийгдсэн газрын фото зураг	4.2. Хэмжилт, зураглал -Кадастрын зураглал хийсэн мэргэжлийн байгууллага болон хэмжилт хийсэн хүний нэр:  -Аймгийн Байгаль орчны газрын мэргэжилтэн Н.Сүх-ялалт, байгаль хамгаалагч Т.Болдбаатар -Хэмжилтэд ашигласан программ, тоног төхөөрөмж:	

	<p>-GPS гар багажаар координатын цэг авч, Google earth зураг дээр тэмдэглэл хийсэн.</p> <p>- Холбогдох утас: 88134564</p> <p>Гарын үсэг: .....</p> <p>.....</p>
<p>4.3 Нөхөн сэргээлт хийсэн газрын солбицол</p> <p>Жич: 4-өөс доошгүй эргэлтийн цэгийн солбицол байна.</p>	<p>-Техникийн нөхөн сэргээлт:</p> <p>Хавсралтаар зураг солбицлыг оруулав</p>
<p>Нөхөн сэргээлт хийсэн газарт хэмжилт хийж талбайн хэмжээг тогтоон полигон хэлбэрээр share.file үүсгэн флаш болон CD-нд хуулж акттай хавсаргана.</p>	
<p><b>5. Мэдээллийн сангийн бүртгэл</b></p>	
<p>Нөхөн сэргээлтийг хүлээн авсан ажлын хэсэг нь Байгаль орчны мэдээлллийн сангийн <a href="http://www.eic.mn">www.eic.mn</a> цахим системийн Нөхөн сэргээлтийн мэдээллийн дэд санд заавал бүртгүүлнэ.</p> <p>Жич: Мэдээллийн санд бүртгээгүй тохиолдолд нөхөн сэргээлтийг хүлээн авсан актыг хүчинтэйд тооцохгүй.</p> <p>Мэдээлэл оруулсан хүний нэр, албан тушаал: Н.Сүх-ялалт, Байгаль орчны газрын газар зүйн мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн.</p> <p>Гарын үсэг:</p> <p>Огноо:</p> <p>Нэмэлт мэдээлэл:</p>	

Нөхөн сэргээлтийн ажил нь холбогдох хууль, журам, стандартад нийцсэн талаарх ажлын хэсгийн дүгнэлт:

“ДОЦ” ХХК-ийн 2025 онд хүлээлгэн өгч байгаа нөхөн сэргээлтийн ажлын үр дүнг аймгийн Засаг даргын 2020 оны А/500 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн газар дээр нь хянаж, хэмжилт хийн ажилласан.

Гүйцэтгэсэн нөхөн сэргээлт нь Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны А-138 дугаар тушаалаар батлагдсан аргачлал, MNS5917:2008, MNS5918:2023 стандартын шаардлагыг хангаж байна.

Тиймээс ажлын хэсгийн гишүүдийн 100 хувийн саналаар “ДОЦ” ХХК-ийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хүрээнд хийж гүйцэтгэсэн 0,46 га талбайн техникийн нөхөн сэргээлтийн ажлын үр дүнг актаар хүлээн авахаар шийдвэрлэсэн.

АКТ ГАРГАСАН:

Дарга:  
А.Гантулга - Байгаль орчны газрын дарга



Нарийн бичгийн дарга:  
Н.Сүх-Ялалт - Байгаль орчны газрын газрын хэвлий, түүний баялагийн ашиглалт, нөхөн сэргээлт, Газарзүйн мэдээллийн систем хариуцсан мэргэжилтэн

Гишүүн:

Н.Билгүүнзаяа - Байгаль орчны газрын байгаль орчны хяналтын улсын байцаагч

Б.Батдорж - Хэрлэн голын сав газрын захиргааны мэргэжилтэн

Ж.Саран - Хэрлэн сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч


Т.Болдбаатар - Хэрлэн сумын байгаль хамгаалагч

ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРСӨН:



Б.Базаргүр "ДОЦ" ХХК-ийн захирал




---oOo---




ТАНИХ ТЭМДЭГ

-  Нөхөн сэргээлт хийхээр төлөвлөж байгаа талбай /0.4 га/
-  Нөхөн сэргээлт хийсэн талбай /0.46га/



ТАНИХ ТЭМДЭГ

Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл

 Ашиглалтын

 Хайгуулын

Засаг захиргааны хил

 Улсын хил


 Аймгийн хил


 Сумын хил


 Аймгийн төв


 Сумын төв

Тусгай хамгаалалттай газар нутаг


 Дархан цаазат газар


 Байгалийн цогцолборт газар

 Байгалийн нөөц газар


 Дурсгалт газар


Хамгаалалтын бүсүүд

 Гол мөрний урсац бүрэлдэх эх


 Ойн сан бүхий газар


Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс


 Онцгой хамгаалалтын бүс

 Энгийн хамгаалалтын бүс


Ус хангамжийн эх үүсвэр

 Эрүүл ахуйн хориглолтын бүс

 Эрүүл ахуйн хязгаарлалтын бүс

 Тэжээгдлийн муж

Орон нутгийн усны хамгаалалтын бүс

 Орон нутгийн усны хамгаалалтын бүс

Масштаб 1:6119.0

Аймаг, сум, сав газрын нэр: Дорнод аймаг Хэрлэн сум, Хэрлэн голын сав газар

Засгийн газрын 2012 оны 194, 2015 оны 289-р тогтоолоор батлагдсан гол, мөрний урсац бүрэлдэх эхтэй давхцалгүй, ойн сантай давхцалгүй, усны сан бүхий газрын хамгаалалтын бүстэй давхцалгүй, улсын тусгай хамгаалалттай газар нутагтай давхцалгүй байна. Орон нутгийн усны энгийн болон онцгой хамгаалалтын бүстэй давхцалгүй байна.



Огноо: 2025-02-03